

**“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

Дугаар 01/2024

2024-04-03

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны үр  
дүн, 2024 оны үндсэн зорилтын тухай

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон 2024 оны үндсэн зорилт, үзүүлэлтүүдийн тухай хэлэлцсэн, хувьцаа эзэмшигчдийн санал, шүүмжлэл болон тооллогын комиссын хураалтын үр дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны үр дүнг тайлангаар хүлээн зөвшөөрсүгэй.

2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг дараахь байдлаар тогтоон баталсугай.

- Үйлдвэрлэл	52000 м2
- Борлуулалт	6 200 000,0 мян. төг
- Хөрөнгө оруулалт	600,0 сая төг
- Цэвэр ашиг	900,0 сая төг
- Үйлдвэрлэлийн нэгж өртөг	94000 төг/м2

3. Компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр тавьж буй үндсэн зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд 2024 онд компанийн техник, технологи, эдийн засгийн нөөц бололцоог илүү үр ашигтайгаар удирдан зохион байгуулж ажиллахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА  Ё.ЭНХТӨР



УЛААНБААТАР ХИВС ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ

Дугаар 03/2024

2024-04-03

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгож  
батлах тухай

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар явагдсан ТУЗ-ийн гишүүдийн санал хураалтын үр дүнгийн талаархи тооллогын комиссын 03 ба 04-р тогтоолуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

- Цоодолын ЗОРИГТ
- Лувсангийн ЦЭНДЭЭХҮҮ
- Зоригтын МӨНХМАА
- Шагдарсүрэнгийн ЭНХБАЯР
- Зоригтын ЭРДЭНЭЭ
- Уламбаярын МӨНХЗУЛ

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

- Цэвэгдоржийн ЭНХБОЛД
  - Ёндонжамцын ЭНХТӨР
- Баттулгын БАЯСГАЛАН

2. Монгол улсын Компанийн тухай хуулийн 75-81-р заалтууд болон Компанийн дүрэмд заасан эрх үүргүүдийг хэрэгжүүлж, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг зохих журмын дагуу зохион байгуулан ажиллуулж, компанийн гүйцэтгэх удирдлага хамт олныг 2024 оны төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллахад нь шуурхай удирдлагаар хангаж, чиглүүлэн ажиллахыг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА



Ё.ЭНХТӨР

УЛААНБААТАР ХИВС ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ

Дугаар 04/2024


2024-04-03

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл  
ажиллагааы зардлын төсвийг  
батлах тухай

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн ТУЗ болон хороодын зардлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн санал, шүүмжлэл болон тооллогын комиссын санал хураалтын үр дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ болон хороодын 2024 оны үйл ажиллагааны зардлыг 88,020.0 мян. төгрөгөөр, /Хавсралт №1/ тогтоон баталсугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА  Э.ЭНХТӨР

"Улаанбаатар хивс" ХК-ийн ТУЗ-ийн  
2024-02-16-ны өдрийн  
04/2024 тогтоолын хавсралт №1



ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны зардлын төсөв

№	Зардлын товч утга	Нийт дүн [₮]
1	<u>Цалин:</u> - ТУЗ-ийн дарга х 12 сар х 740.0 мян. ₮ - Гишүүд: 8 х 12 сар х 500.0 мян. ₮ - ТУЗ-ийн нбд х 12 сар х 620.0 мян. ₮ <u>Хурлын ирцийн нэмэгдэл:</u> - 10 хүн х 12 сар х 160.0 мян. ₮	₮ 83,520,000.00
2	Бичиг хэрэгслийн зардал	₮ 500,000.00
3	Хэвлэл, телефон холбооны зардал	₮ 2,000,000.00
4	Бусад, сургалт, аттестатчилал	₮ 2,000,000.00
	Дүн	₮ 88,020,000.00